




БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НЯМХАТАН

*Б.Нямхатан*



БАТЛАВ.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА *С.Монгол* С.МОНХЦЭЦЭГ



**“ЭКО СУРГУУЛЬ”, “ЭКО ЦЭЦЭРЛЭГ” ШАЛГАРУУЛАХ  
АЯНЫ УДИРДАМЖ**

2020.11.01

Чингис хот

**ҮНДЭСЛЭЛ**

Байгаль орчны бохирдол, доройтлын асуудал нь Монгол улсын хэмжээнд төдийгүй дэлхий нийтийн өмнө нэн тэргүүнд тавигдаж байна. Тогтвортойгоор урт удаан хугацаанд нийтээрээ нэг дэлхий дээр оршин тогтнох, ирээдүйн сайн сайхан амьдралын төлөө бид байгаль эх, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах нь нэн чухал юм. Хэntий аймгийн “Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2026” дунд хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, Эко сургууль; Эко цэцэрлэг шалгаруулах аяныг зарлаж байна.

## “ЭКО СУРГУУЛЬ” ШАЛГАРУУЛАХ АЯНЫ УДИРДАМЖ

### НЭГ. Зорилго:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчидыг байгаль орчныг хамгаалах зөв дадал олгох, байгаль хамгаалах үйлсэд татан оролцуулах, тэдний сэтгэлгээг зөвхөн байгаль орчныг хэрэглэгч байдлаас хайрлан хамгаалагч болгон төлөвшүүлэн тогтвортой боловсрол олгоход оршино.

### ХОЁР. Хугацаа:

2020.11.02-2020.12.02

### ГҮРАВ. Хамрах хүрээ:

Хэнтий аймгийн төрийн өмчийн болон хувийн хэвшлийн ЕБС-иуд

### ДӨРӨВ. Аянд оролцох сургуулиудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. ЕБС-ийн “ЭКО КЛУБ” – нь байнгын үйл ажиллагааг тогтвормжуулах
  - Эко клубын сурагчид сургууль дээрээ эко төсөл хэрэгжүүлж, бодит үр дүнд хүрсэн байх
  - Сургуулийн байгальд ээлтэй уриа логотой болж сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байх
2. Багш, ажилчид, хүүхдүүдийн дунд доорх чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна.
  - Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, дахин ашиглах
  - Байгаль орчныг хамгаалах уламжлалт болон орчин үеийн арга
3. Дахивар хог хаягдал цуглуулах /хуванцар, лааз, гялгар уут/
  - Дахивар хог хаягдал цуглүүлж, аймагт дахивар хог хаягдал авдаг аж ахуйн нэгж байгууллагад тушаах
  - Сургуулийн орчинд ангилан ялгах хогын сав байршуулах

### ТАВ. Шалгүүр үзүүлэлт

1. Эко клубын хэрэгжүүлсэн Эко төслийн санаа, үр дүн
2. Багш, ажилчид, хүүхдүүдийн дунд хийсэн сургалтын тоо, сургалтанд хамрагдсан хүний тоо, сургалтын үр дүнг сургууль дээр очиж түүврийн аргаар 10 сургач сонгон тестээр шалгах
3. Дахивар хог хаягдлыг цуглуулж, тушаасан хэмжээ

### ЗУРГАА. Анхаарах зүйлс

1. Эко төслийн санаа нь сургуулийн орчинд хэрэгжүүлэх боломжтой байх
2. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх, заавар зөвлөмжийг дагаж мөрдөх
3. Дахивар хог хаягдлыг зөвхөн эх үүсвэр дээрээс цуглуулах /хогын цэг ухах, гудамж талбайгаас түүхийг хориглоно./

4. Аяны тайланг шалгуур үзүүлэлтын дагуу тодорхой бичиж, холбогдох зургыг хавсаргах

**ДОЛОО. Хамтран зохион байгууллагч байгууллага**

Байгаль орчин аялал жуулчлалын газар

Боловсрол, соёл, урлагийн газар

**НАЙМ. Шалгаруулалт:**

ЕБСургууль аяны хугацаанд хийсэн ажлын талаарх мэдээллийг сонин, ТВ, вебсайт гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, 2020.12.05-ны дотор бичмэл тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

Аяныг дүгнэхдээ ЕБСургуулиас ирүүлсэн тайланг үндэслэн аяныг хамгийн сайн зохион байгуулсан 5 ЕБСургуулийг шалгаруулж, тэдгээр байгууллагуудад очиж үзэн, 1-3 байр эзлүүлэн шалгаруулж, дараах шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

1-р байр /1/ - Өргөмжлөл, 800.000 төгрөг

2-р байр /1/ - Өргөмжлөл, 500.000 төгрөг

3-р байр /1/ - Өргөмжлөл, 300.000 төгрөг

**ЕС. Холбоо барих:**

- Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар  
Хэрлэн сумын ЗДТГ-ын байр 205 тоот мэргэжилтэн Б.Санчир 70562506, 89724001,  
мэргэжилтэн Г.Баярцэцэг 88194323
- Боловсрол, соёл урлагийн газар  
Боловсрол соёл урлагийн газрын байр  
Байгалийн ухааны сургалт хариуцсан мэргэжилтэн Д.Болорчимэг 99920406,

--Оо--

## “ЭКО ЦЭЦЭРЛЭГ” ШАЛГАРУУЛАХ АЯНЫ УДИРДАМЖ

### НЭГ. Зорилго:

Цэцэрлэгийн багачуудыг байгаль орчныг хамгаалах зөв дадал олгох, байгаль хамгаалах үйлсэд татан оролцуулах, тэдний сэтгэлгээг зөвхөн байгаль орчныг хэрэглэгч байдлаас хайрлан хамгаалагч болгон төлөвшүүлэн тогтвортой хөгжлийн боловсрол олгоход оршино.

### ХОЁР. Хугацаа:

2020.11.02-2020.12.02

### ГУРАВ. Хамрах хүрээ:

Хэнтий аймгийн төрийн өмчийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүд

### ДӨРӨВ. Аянд оролцох сургуулиудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Эко уриалга боловсруулах

- Цэцэрлэг байгальд ээлтэй уриа логотой болох цэцэрлэгийн захиргаа олон нийтэд сурталчилсан байх /Энэхүү аянд эцэг эхчүүдийн оролцоог хангах /

2. Хүүхдүүдийн дунд доорх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна.

- Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, дахин ашиглах талаар хүүхдэд ойлгомжтой видео хичээл бэлтгэж хүүхдүүдийг хамруулсан байх

3. Цэцэрлэг эко булантай болох

- Эко буланг шинэлэг санаагаар тохижуулсан байх  
/Хог хаягдлыг ангилан ялгах ном, тохимол, зурагт хуудас, тоглоом г.м тохижилтонд оруулах/

4. Гадна, дотно орчны хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар бүтээлч болон төлөвшлийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

- Цэцэрлэгийн орчинд болон ангиудад ангилан ялгах хогийн сав байршуулах
- Багш нар хаягдал зүйлс ашиглан хүүхдүүдэд зориулсан тоглоом хийсэн байх  
/Тоглоом нь доорх шаардлагыг хангасан байна/

- ✓ Хүүхдэд аюулгүй стандартын шаардлагад нийцсэн байна
- ✓ Хүүхдийн сонирхол татахуйц байна
- ✓ Хүүхэд тоглож байх явцдаа хог ангилан ялгах дадал зуршил суух зориулалттай байх
- ✓ Тоглоомын түүхий эд нь хямд төсөр олдоцтой байх
- ✓ Тоглоомыг бусад цэцэрлэгүүд сургалтандaa нэвтрүүлэх боломжтой байх/

Цэцэрлэгийн захиргаа шилдэг нэг тоглоомыг өөрсдөө шалгаруулж бүтээлийг БОАЖГ-т ирүүлэх

ТАВ. Цэцэрлэгийн захиргаа нь дээрх үйл ажиллагаанаас шалгарсан бүтээлийг тайлангийн хамт БОАЖГ-т ирүүлиэ.

- 1.Шилдэг нэг уриалга
- 2.Шилдэг нэг видео хичээл
- 3.Цэцэрлэгийн Эко булангийн танилцуулга
- 4.Шилдэг нэг тоглоом

#### **ЗУРГАА. Шалгаруулалт**

- 1.Уриалга нь ойлгомжтой шинэлэг өвөрмөгц байх
- 2.Цэцэрлэг дээр очиж түүврийн аргаар 10 хүүхэд сонгон тестээр шалгах
- 3.Видео хичээл нь ойлгомжтой,сонирхол татахуйц,хөгжөөнтэй байх
- 4.Эко булан сонирхол татахуйц, мэдлэг нэмэх, нээлттэй байх
- 5.Цэцэрлэгийн гадна,дотно орчинд ангилан ялгах хогийн савны хүртээмжээр
- 6.Тоглоом нь стандарт хангасан, шинэлэг, хөгжөөнтэй, сонирхол татахуйц байх

#### **ДОЛОО. Анхаарах зүйлс**

- 1.Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх, заавар зөвлөмжийг дагаж мөрдөх
- 2.Аяны тайланг шалгуур үзүүлэлтын дагуу тодорхой бичиж, холбогдох зургыг хавсаргах

#### **НАЙМ . Шалгаруулалт:**

Цэцэрлэг аяны хугацаанд хийсэн ажлын талаарх мэдээллийг сонин, ТВ, вебсайт гэх мэт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж, 2020.12.05-ны дотор бичмэл тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

Аяныг дүгнэхдээ Цэцэрлэгээс ирүүлсэн тайланг үндэслэн аяныг хамгийн сайн зохион байгуулсан 5 Цэцэрлэгийг шалгаруулж, тэдгээр байгууллагуудад очиж үзэн, 1-3 байр эзлүүлэн шалгаруулж, дараах шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

- 1-р байр /1/ - Өргөмжлөл, 800.000 төгрөг
- 2-р байр /1/ - Өргөмжлөл, 500.000 төгрөг
- 3-р байр /1/ - Өргөмжлөл, 300.000 төгрөг

#### **ЕС. Холбоо барих:**

- Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар  
Хэрлэн сумын ЗДТГ-ын байр 205 тоот мэргэжилтэн Б.Санчир 70562506, 89724001,  
мэргэжилтэн Г.Баярцэцэг 88194323
- Боловсрол, соёл урлагийн газар  
Боловсрол соёл урлагийн газрын байр  
Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнгөнбаяр 99008440